



**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН “28” ДАХЬ УДААГИЙН
2026 ОНЫ БАГШ, АЖИЛЧДЫН СПОРТЫН НААДМЫН НИЙТИЙН
ГИМНАСТИКИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

Улаанбаатар хот

ШУТИС-ийн багш ажилчдын спортын наадмыг Багшийн хөгжлийн төв, ХШУС-ийн Биеийн тамир, спортын тэнхим хамтран 2026 оны 01 дүгээр сарын 12-18 -ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэж байгаа билээ.

Спортын наадмын “НИЙТИЙН ГИМНАСТИК”-ийн тэмцээнийг Монголын гимнастикийн холбоотой хамтран **2026** оны **01** дүгээр сарын **15**-ны өдөр 10:00-12:00 цагийн хооронд хичээлийн 2-р байрны спортын танхимд 2 төрлийн заавал хийх дасгалаар зохион байгуулна. Үүнд:

- 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрөл
- 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрөл.

#НИЙТЛЭГ_ШААРДЛАГА:

- Спорт наадмын “Нийтийн гимнастик”-ийн тэмцээний багийн бүрэлдэхүүнд бусад спортын төрлийн (*Волейбол, Сагсан бөмбөг, Ширээний теннис, Шатар*) тэмцээнд оролцож байгаа тамирчин оролцохгүй тухайн сургуулийн санхүү, салбар тэнхимийн эрхлэгч, сургалтын алба, үйлчилгээний ажилтан, сургалтын мастер зэрэг 12 хүний бүрэлдэхүүнтэй байна. (**Жич: Зарим Бүрэлдэхүүн сургуулийн онцлог, боловсон хүчний нөөц, орон нутгаас оролцох багийн бүрэлдэхүүнээс хамаарч Сагсан бөмбөг, Волейболын эрэгтэй/ эмэгтэй багаас нийтдээ хүйс хамаарахгүй 2 хүртэлх тоглогчийг нийтийн гимнастикийн тэмцээнд оролцуулахыг зөвшөөрнө.**) гэж нэгдсэн удирдамжид заасны дагуу багийг хүйс харгалзахгүйгээр бүрдүүлэх бөгөөд **2026** оны **01** дүгээр сарын **05**-ны **15:00** цагт ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 1-203 өрөөнд болох техникийн зөвлөгөөний хуралд БХТ-ийн төлөөлөл, багийн ахлагчийн хамтаар мэдүүлгийг (*2025 оны 01 тоот тушаал, ... захирлын тушаал*) шаардлагад нийцүүлэн авч ирнэ.
- Нийтийн гимнастикийн тэмцээн нь 2 төрлөөр зохион байгуулагдаж төрөл тус бүрд 1, 2, 3-р байрыг эзлүүлж медаль, өргөмжлөлөөр шагнах бөгөөд нийлбэрээр байгууллага, бүрэлдэхүүн сургуулийн амжилтыг нэгтгэж дүгнэнэ.

#ТЭМЦЭЭНИЙ_ӨМНӨ:

- Тэмцээнд оролцох багуудын сугалааны дарааллыг **2026** оны **01** дүгээр сарын **05**-ны өдөр **15:00** цагт бүртгэж, зохион байгуулна. Тэмцээнийг 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрлөөр эхэлж, 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрлөөр үргэлжлүүлж дуусгана.
- Бүрэлдэхүүн сургуулиудын багууд нь сугалааны дарааллын дагуу **2026** оны **01** дүгээр сарын **15**-ны Пүрэв гаргийн өглөө 08:30 цагаас 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”, 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрлөөр талбайд гарч 1/1 удаа бэлдэнэ. Өөрийн дарааллын дагуу талбайд гарч бэлдээгүй бол нөхөж гарах боломжгүйг анхаарна уу.
- Зохион байгуулалтын талаар тухайн БХТ-ийн ахлагч/төлөөлөгч, эсвэл БС-ийн багийн ахлагч /сонгогдсон 1 хүн/ тухайн тэмцээнийг зохион байгуулагч багш /Г.Ерөөлбат/-тай холбогдож мэдээлэл авч, өгч ажиллана.
- Нээлтийн ажиллагаанд зориулж дасгалын үндсэн ая дээр бүх багууд нэгдсэн бэлтгэлийг талбайд гарах дарааллын дагуу оногдсон хэсэгт цуваагаар зогсож хийж гүйцэтгэнэ. (Нээлтийн ажиллагаанд 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн нэгдсэн дасгал хийгдэхгүй болно.)
- Талбайд заалны зориулалттай кет, пүүз өмсөнө.
- Зохион байгуулагчдын зүгээс 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн дасгалд зориулж 3ш (дугуйгүй, 4 хөлтэй, түшлэгтэй) хар өнгийн сандлыг бэлтгэсэн байна. Хэрэв багууд өөрсдийн бэлтгэсэн сандлыг ашиглах бол зохион байгуулагч багшид урьдчилан мэдэгдэнэ.

#ТЭМЦЭЭНИЙ_ҮЕД:

- Спорт наадмын “Нийтийн гимнастик”-ийн тэмцээний нээлтэд дасгалыг үндсэн ая дээр бүх багууд нэгдсэн байдлаар, оногдсон хэсэгт цуваагаар зогсож хийж гүйцэтгэн тэмцээний видео бичлэг, фото зурагт тэмцээний хувцастай орно.
- Дарааллын дагуу багууд зарласнаас хойш 20’ секундийн дотор талбайн баруун/ зүүн хэсгээс талбайд гарч байраа эзэлнэ. Багууд талбайд ёсолгоо хийнэ, талбайн соёлыг хүндэтгэж оролцоно.
- Дасгалын аяныг өөр аяар сольсон бол зохион байгуулагч багшид (*аудио оролттой, холбогчийн хамтаар эсвэл онгоцны горимд оруулсан түгжээгүй гар утсыг*) 1 тоглолтын өмнө өгнө.
- Тэмцээнийг Монголын гимнастикийн холбооноос итгэмжлэгдсэн 2025-2028 оны олимпын циклийн бүрэн эрхтэй, сондгой тооны олон улсын шүүгч нар шүүн явуулах тул аливаа хэл ам гаргах, багийн болон багийн бус хөндлөнгийн хэн нэгнээр ёс зүйгүй бүдүүлэг авир гаргахыг хүлээн зөвшөөрөхгүй, бүдүүлэг үйлдэл гаргасан тохиолдолд БС-ийн багийн амжилтыг 0,00 үнэлгээгээр дүгнэнэ.
- Багуудын хувцаслалт
 - Багийн хувийн бэлтгэлийн сайтар хангаж, үсний боолт задрах, унах, чешка сугарч унахаас бүрэн сэргийлэх ёстой. Талбайд чешка, үсний боолт унах удаа бүрд нийлбэр дүнгээс -0,1 оноо хасана.

- Хэрэв оролцогчийн тоо дутуу бол тухайн дасгалын дутуу гишүүн бүрээс -1,0 оноог эцсийн онооноос хасаж байр эзлүүлэн дүгнэнэ.
- Оролцогчийн үсийг элдэв төрлийн саа, өнгөтэй лак түрхэх, саа шигтгээг толгой, үс, нүүрэнд наахыг хатуу хориглоно. Мөн багийн гишүүдийн үсийг нийтээр нь ижил захалж хээ дүрс үүсгэх, нүүр, нүдийг будахыг хатуу хориглоно. Эмэгтэй оролцогчдын нүүрийг хөнгөн будахыг зөвшөөрөх бөгөөд хэтрүүлэн будах (*Хэтрүүлэн тод, бараан өнгөөр нүд, уруулыг будахгүй*), театрын будалт хийхийг хатуу хориглоно. Хэтрүүлэн будсан тохиолдол бүрээс -1,0 оноог эцсийн онооноос хасаж дүгнэнэ.
- Үсний боолтоос гадна толгойн элдэв төрлийн чимэглэл хийхгүй, хөдөлгөөн хийхэд саад болохгүй байх, хийж чимэглэсэн тохиолдолд оролцогч бүрийн тоогоор -0,1 оноог эцсийн онооноос хасаж дүгнэнэ.
- Хувцаслалтын ерөнхий шаардлагыг хангасан бие эвтэйхэн жигд хувцасласан байх ёстой. Хэт бүжгийн хэлбэртэй хувцас, биеийн өнгөтэй материалаар хийгдсэн садар самууныг сурталчилсан, хүнд рок чимэг, спортын биш шашин, арьс өнгө, дайн байлдаан, хүчирхийллийн агуулгагүй, үлгэрийн баатар, амьтны хэлбэр дүрстэй хувцас, баг өмсөхгүй бөгөөд олимпизмийн үзэл санааг зөрчиж өмссөн бол -1,0 оноог эцсийн онооноос хасаж дүгнэнэ.
- Тэмцээний явцад шүүгчийн нарын ажиллагаанд саад учруулах, зураг авах, бичлэг хийж шүүгч нарын урдуур явах, гүйх, асран хамгаалагчгүй хүүхдийг орхиж явах, элдэв төрлийн бөмбөлөг, шаар, тоглоом, хэрэглэгдэхүүнийг талбай руу алдаж оруулахгүй байх онцгой анхаарах.


#ТЭМЦЭЭНИЙ_ХААЛТЫН_АЖИЛЛАГААНЫ_ҮЕД:

- Спорт наадмын “Нийтийн гимнастик”-ийн тэмцээний нээлтэд зогссон дарааллаар дасгалыг үндсэн ая дээр бүх багууд нэгдсэн байдлаар, оногдсон хэсэгт цуваагаар зогсож хийж гүйцэтгэн тэмцээний видео бичлэг, фото зурагт тэмцээний хувцастай орно.
- Тэмцээнд эзэлсэн байрыг зарлаж, танилцуулан **2026** оны **01** дүгээр сарын **18**-ны Ням гаргийн орой Спорт наадмын нэгдсэн хаалт дээр 1, 2, 3-р байрт шалгарсан багууд нэгдсэн тоглолтыг хийж, шагналыг гардуулах тул шагналт байр шалгарсан багууд тэмцээний хувцастай ирж гардаж авна.


#АНХААРУУЛГА:

1. Заавал хийх дасгалыг яг тэр хэвээр нь хийнэ. Хөдөлгөөнийг өөрчлөх, чиглэл, баруун зүүн талуудыг солихгүй (толин тусгалаар хийхгүй, бичлэг дээрх хүнтэй адил чиглэлд) хийнэ.
2. Дасгал хөдөлгөөний шүүлт нь жигдрэл (синхрон), дасгалын бүрэн бүтэн байдал, хөгжим хөдөлгөөний тохироо (timing) зэрэг үндсэн 3 бүлгээр мэргэжлийн шүүгч нар шүүнэ.
3. Хувцаслалт жигд хувцастай байх.

4. Багийн бүрэлдэхүүнд заасан албан тушаалтнаас гадна тэмцээн оролцоогүй хүмүүсээс багийг бүрүүлэх (Заасан 5 албан тушаалтан тухай бүрэлдэхүүн нэгжийн онцлогоос хамаарч эсвэл хүндэтгэх шалтгааны улмаас оролцох боломжгүйд хүрсэн бол нотлох баримтыг үндэслэн бусад багш ажилчдаас удирдамжид заасны дагуу 9-12 хүртэлх оролцогчийг оролцуулна.) Дасгалын 2 төрөлд 9-12 хүртэлх тооны оролцогчид нь 2 төрөлд давхардаж оролцож болно.
5. Талбайд орох, гарахад зохиомжилж болох ба оноод нөлөөлөхгүй (Дасгалын үндсэн хөдөлгөөнд өөрчлөлт оруулахгүй байх!)
6. Дасгалын үргэлжлэх хугацааг идэвхтэй хөдөлгөөнөөс хэмжинэ. Дасгалын аяыг өөр аяар орлуулж хийж болох бөгөөд дасгалын хугацааг баримтална. Үүнд:
 - 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрөлд **3 мин 05’ секунд** (+/- 5 секунд буюу 3 мин 00”-ээс 3 мин 10’ секунд байж болно).
 - 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрөлд **2 мин 36’ секунд** (+/- 5 секунд буюу 2 мин 31”-ээс 2 мин 41’ секунд байж болно).
7. Талбайн байрлал:
 - **3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрөлд**




- **9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрөлд**



8. Багууд дараах холбоосыг ашиглан #дасгалыг_татаж авч бэлтгэлээ сайн хангахыг хүсье!


- 2026 оны нийтийн гимнастикийн 3 хүний бүрэлдэхүүнтэй “Оюуны ажил хөдөлмөр эрхлэгчдийн баг”-ийн төрлийн дасгалын линк:

https://www.youtube.com/watch?v=NqFHwtxTPnE&list=RDNgFHwtxTPnE&start_radio=1



- 2026 оны нийтийн гимнастикийн 9 хүний бүрэлдэхүүнтэй “Шугаман бүжиг”-ийн багийн төрлийн дасгалын линк:

https://www.youtube.com/watch?v=6WUNB-EQbsc&list=RD6WUNB-EQbsc&start_radio=1



Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2026 оны багш ажилчдын 28 дахь удаагийн спортын наадамдаа Эв нэгдэл, Авхаалж самбаагаа сорин өрсөлдөхөөр бэлтгэж буй бүрэлдэхүүн сургуулийн багууддаа Спортын өндөр амжилт хүсье!!!

#Хамтын хүч АМЖИЛТ!!!



БАГШИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ,
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ТЭНХИМ,
ШУТИС-ийн “Лос Анжелес-2028” Олимпын танхим